

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ АСУУДЛААР
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт тус тус заасныг баримтлан Өргөдлийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг нэр дэвшүүлэхээр Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн санал гаргасан болно.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийг нэр дэвшүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өргөдлийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



М.БИЛЭГТ